# ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
# 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Төлөвлөгөөг хянасан:* ***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА........................................./Д.ДЭЛГЭРСАЙХАН/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*Тэмдэг* .....................

*(огноо)*

*Төлөвлөгөө баталсан:* ***Төсвийн Шууд захирагч***

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА ........................................................./М.ОТГОНБАЯР/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

ГСТ7153 2023020004

*Тэмдэг* *2023.11.27*

*(огноо)*

**ОРХОН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2023.11.27

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | *Гүйцэтгэлийн хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛГО: БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАМ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ** | | | | | | | |
| **Зорилт 1**.Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна. | | | | | | | |
| 1.1 | Тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулах | | Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн хувь | 21 | 35 | Аймгийн хэмжээнд олговол зохих 73598 иргэнээс 2023 оны жилийн эцсийн байдлаар 24621 тоон гарын үсэг буюу 34,5 хувьд нь олгоод байна. | 95 |
| 1.2 | Чанарын удирдлагын тогтолцоогоор гарсан журмуудыг хэрэгжүүлэх | | Журам хэрэгжилтийн хувь | - | 100 | Чанарын удирдлагын тогтолцооны 10 журам боловсруулж хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган бүртгэгч бүрт хариуцуулан, биелэлт үр дүнг тооцон ажилласны үр дүнд иргэд үйлчилгээг шуурхай авч ямар нэг гомдол саналгүй ажиллаа. | 100 |
| 1.3 | Шинэчилсэн загвараар олгогдсон иргэний үнэмлэхний чипэнд хаягийн хөдөлгөөний бичилт хийх | | Бичилт хийгдсэн иргэний үнэмлэхний хувь | - | 100 | Шинэчилсэн загвараар иргэний үнэмлэх 4942 иргэнд олгосноос шинээр бүртгүүлсэн 1511 иргэн,хаяж үрэгдүүлсэн 589 иргэнд,25,45 насны хугацааны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сунгалтыг 1107 иргэнд тус тус олголоо. | |
| 1.4 | Цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэх | | Олгосон цахим гадаад паспортын тоо | - | Хүсэлт гаргасан иргэдийн тоогоор | 2023 оны жилийн эцсийн байдлаар 9233 иргэнд гадаад паспорт олгосноос 5746 иргэнд цахим гадаад паспорт,3487 иргэнд энгийн цахим паспорт олголоо. | 100 |
| 1.5 | Байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм журам зааврыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулахад санал хүргүүлэх,иргэдэд сурталчлах | | Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн сурталчилгааны тоо | 3 | 5 | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар контент бэлтгэн орон нутгийн 9 ТВ,12 сайтуудаар 3 удаа иргэдэд түгээж сурталчиллаа.Авлигын эсрэг хуулийн сурталчилгааг 35 удаа,бүртгэлтэй холбоотой мэдээ мэдээлэлийг орон нутгийн 9 телевизээр 8 удаа ,тоон гарын үсгийн тухай болон цахим гадаад пасспорт,шилжилт хөдөлгөөний журамын тухай 26 багийн нээлттэй хаалганы өдөрлөгөөр давхардсан тоогоор 2636 иргэнд түгээж сурталчиллаа. | 100 |
| 1.6 | Бүртгэлийн үйлчилгээг мэдээлэлийн технологийн арга хэрэгслээр үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх | | -цахим машины тоо | 1 | 2 | Аймгийн Засаг Даргын хөрөнгө оруулалтаар 1 киоск машин худалдан авч нэг цэгийн үйлчилгээн дээр, үйлчилгээний танхимд 1 машин тус тус байршуулж 2023 онд 2 киоск машинаар иргэдэд цахим үйлчилгээг үзүүлсэн нь бүртгэгч нарт ирэх ачаалалыг бууруулж иргэд цаг хугацаа харгалзахгүй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүндрэл бэрхшээлгүй үйлчилгээ авах боломжийг нь бүрдүүлж чадлаа. | |
| 1.7 | Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх,цахим хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэх | | -Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээний бүртгэлийн тоо | - | 50 | Чингэлтэй дүүрэгт туршилтын бүртгэлийн EPRS -2 туршилтын программ хэрэгжиж байгаа бөгөөд орон нутагт хэрэгжих хугацаа болоогүй гэж ЭХЭУБГ аас мэдэгдсэн учир хэрэгжээгүй болно. | |
| | | | -Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийн тоо | - | 50 | | |
| **Зорилт 2**.Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 2.1 | E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн порталаар үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээний нэр төрөл нэмэгдэх бүрт иргэдэд сурталчилах ажлыг зохион байгуулах | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 4 | **8** | E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн порталаар 67 үйлчилгээ, гар утасны аппликейшнээр 23 үйлчилгээ үзүүлж байна. Хэлтсийн https://orkhon.burtgel.gov.mn/ болон https://www.facebook.com/orkhonburtgel -ээр бүртгэлтэй холбоотой 28 мэдээ мэдээллийг түгээн сурталчилж, 12 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөгт нийт 3000 гаруй иргэнд танилцуулга сурталчилгаа хүргэн ажилласан. Мөн Эрдэнэтийн ETV HD, Номин тв, Эрдэнэт тв, Гэрэгэ тв болон Эрдэнэт инфо сайтад 11 удаа | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ярилцлага өгч мэдээллийг тухай бүр нь хүргэлээ. | |
| 2.2 | Улсын бүртгэлийн цахим мэдээлэлийн санг үнэлж дүгнэлт гаргасны дагуу мэдээлэлийн санг цэгцлэх | | Төлөвлөгөөний хэрэгжилт хувиар | - | 80 | ЭХЭБГ аас ирүүлсэн мэдээлэлийн санг цэгцлэх 1500 тоот дүгнэлтээр 7363 хувийн хэргийн цахим мэдээлэлийн сангийн засвар өөрчлөлтийг хугацаанд нь хийж хариуг хүргүүллээ.Иргэний бүртгэлийн чиглэлээр ИГББ 8 төрлийн бүртгэлийн 36 бүртгэлийг цэгцлэх ажлыг хийлээ.Төрөлт баталгаажаагүй-21,үрчилсэн-2,нэр өөрчилсөний баталгаажилт -4,эцэг тогтоолт-3 гэх мэт бүртгэлийг баталгаажуулж гэрлэсэн-2, эцэг тогтоолт-1,төрсний бүртгэлийн сан дахь -21 бүртгэл тус бүрт дүгнэлт гаргаж баталгаажуулан илтгэх хуудсыг 2023.10.25 нд Иргэний бүртгэлийн газарт хүргүүллээ. | 100 |
| 2.3 | Иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулах | | Цахимжуулсан иргэний бүртгэлийн эх нотлох баримтын хувь | 90 | 100 | ИГББ-н 8 төрлийн 24152 цахим бүртгэл хийснээс 51396 хуудас материалыг бүрэн цахимжуулсан. | 100 |
| 2.4 | Улсын бүртгэлийг хууль тогтоомж холбогдох журмын дагуу хөтлөх | | Үзүүлсэн бүртгэлийн тоо | 38337 | Үйлчилгээ авсан иргэдийн тоогоор | 2023 оны жилийн эцсийн байдлаар Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-13259 ,Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр- 20313 ,хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1874 иргэнд тус тус бүртгэлийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэлээ. | |
| **Зорилт 3. Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг хангах эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 3.1 | Хяналт шалгалтын төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангах | - | Хийсэн хяналт шалгалтын хувь | 50 | 70 | Батлагдсан төлөвлөгөөний дагуу иргэний бүртгэлийн чиглэлээр-2459,эд хөрөнгийн бүртгэлээр-2557,хуулийн этгээдийн бүртгэлээр -401 хувийн хэрэгт , архивын чиглэлээр -2286 хувийн хэрэгт нийт 7703 бүртгэлд тус тус хяналт шалгалт хийж 20 зөрчил илэрснийг тухай бүр нь залруулж ажиллалаа. | 70 |
| 3.2 | Хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргааны материалыг программд тухай бүр нь оруулах | | Шийдвэрлэгдсэн хэрэг маргааны тоо | 60 | 80 | 2023 оны жилийн эцсийн байдлаар хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа-12,үүнээс шийдвэрлэгдсэн-10 хэрэг маргааны материалыг тухай бүр нь программд оруулж бүртгэлээ. | 98 |
| 3.3 | Зөрчлийн тухай хууль,Зөрчил шалган шийдвэрлэх хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх | | Шалган шийдвэрлэсэн зөрчлийн тоо | 30 | 100 | Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хялбаршуулсан журмаар 128 иргэнд 3420000 төгрөгийн торгууль,киоск машинаар 28170000 төгрөгийн торгуулийн арга хэмжээг тус тус авч нийт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 31590 000 төгрөгийн торгуулийг орон нутгийн болон улсын төсөвт оруууллаа. | |
| 3.4 | Улсын бүртгэлийн хөтлөх үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах | | Эрсдэлийн төлөвлөгөөний биелэлт хувиар | - | 80 | УБЕГ ын эрсдэл бууруулах ажлын төлөвлөгөөтэй уялдуулан хэлтсийн төлөвлөгөө гаргаж 8 арга хэмжээ төлөвлөсөнөөс биелэлт 100 хувь, улсын байцаагчийн албан шаардлага дүгнэлт болон ХШГ-н шалгалтаар илэрсэн 8 зөрчлийг арилгуулж хугацаатай албан даалгаврыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэлээ.Гарч байгаа зөрчлийг арилгах давтахгүй байх зорилгоор Иргэний ахлах бүртгэгч Ө.Ганзориг,Эд хөрөнгийн ахлах бүртгэгч С.Жамбалсүрэн нар чиглэлийн бүртгэлээр 2023.09.20,27 ны өдрүүдэд 2 удаа сургалт зохион байгууллаа.Мөн хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа бүртгэлийн мэдээлэлийг 7 хоног бүрийн шуурхайд танилцуулж бүртгэгч нарт үүрэг даалгавар өгч ажилласан нь зөрчил гаргахгүй, эрсдэл буурсан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.5 | Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавин ажиллах | - | -Байршуулсан шилэн дансны мэдээллийн хувь;<br>-Хугацаандаа байршуулсан эсэх; | 100 | 100 | Шилэн дансанд 163 мэдээлэл байршуулахаас 137 мэдээлэлийг цаг хугацаанд 100 хувь байршуулж 26 мэдээлэлийн байршуулах хугацаа болоогүй байна. | 100 |
| 3.6 | Улсын бүртгэлийн Ерөнхий газраас цахим мэдээлэлийн санг үнэлж дүгнэлт гарган мэдээлэлийн санг цэгцлэхтэй холбоотой ажлыг хэлтсийн хэмжээнд зохион байгуулах | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 50 | УБЕГ аас ирүүлсэн 1500 тоот дүгнэлтийг үндэслэн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 7363 хувийн хэргийн цахим мэдээлэлийн сангийн засвар өөрчлөлт,иргэний бүртгэлийн ИГББ н 8 төрлийн 36 бүртгэлийн засвар өөрчлөлтийг баталгаажуулж мэдээлэлийн санг цэгцлэх ажлыг цаг хугацаанд хийж гүйцэтгэлээ. | 100 |
| 3.7 | Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах | | Хэрэглэгчийн үнэлгээ хийсэн эсэх | - | 50 | Үйлчилгээний танхимаар бүртгэлийн үйлчилгээ авсан 50 иргэнээс цаасаар,албан хаагчдаас цахимаар санал асуулга, үнэлгээ авахад иргэд сэтгэл ханамжийн баталгаа 100 хувь гэсэн бөгөөд банк руу явж мөнгө тушаахгүй,хуучин гадаад паспорт ,иргэний үнэмлэх шаардахгүй хөнгөн шуурхай үйлчилгээ авсан гэсэн байна.Албан хаагчдаас нийгмийн асуудал шийдвэрлэлтэд сэтгэл дундуур гэсэн үнэлгээг 92% нь өгсөн ба иргэдээс google forum ашиглан бүртгэгч нарын үйлчилгээ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үзүүлж буй байдалд санал асуулга авахад хамгийн шуурхай сайн үйлчилгээг үзүүлсэн бүртгэгчээр 192 хүний санал буюу 48 хувийн саналыг Иргэний улсын бүртгэгч Н.түвшинжаргал авлаа. | |
| 3.8 | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулах, тайлагнах | | -төсвийн хуулийн хэрэгжилтийн хувь | 100 | 100 | 2023 оны 11 сарын байдлаар 646,5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 631,6 сая төгрөгийг зарцуулж төсвийг зориулалтын дагуу зүй зохистой 14,8 сая төгрөгийн хэмнэлттэй зарцуулж ирлээ.Санхүүгийн хугацаатай тайлан мэдээг цаг хугацаанд нь хүргүүллээ. | 100 |
| 3.9 | Хуулийн этгээдийн бүртгэлийн архивын баримтанд сэдэвчилсэн тооллого хийх | | Тооллого хийгдсэн эсэх | - | 1 | Төлөвлөгөөт шалгалтаар 401 хувийн хэрэгт сэдэвчилсэн тооллого хийж,алдаа зөрчлийг тухай бүр нь засч арилгууллаа. | 100 |
| 3.10 | Аудитын газар болон бусад байгууллагаас ирүүлсэн зөвлөмж мэдээ тайланг хугацаанд нь холбогдох газарт хүргүүлэх | | Зөвлөмж акт шаардлагын биелэлтийн хувь | 90 | 100 | 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй дүгнэлт,2 зөвлөмж авсан болно. Зөвлөмжийн биелэлтийг 100 хувь биелүүлж 5 сарын 29 ны өдрийн №650 тоот албан бичгээр биелэлтийг хүргүүллээ.ТӨБЗГ-н тайланг нь хугацаанд нь хүргүүлж гэрээний хэрэгжилт 93% иар дүгнэгдлээ. | 100 |
| 3.11 | Эд хөрөнгийн архивын зориулалтын нягтаршуулсан | | УБЕГ нийлүүлэх төсөл хэрэгжүүлэх | - | 20 | Аймгийн ЗДТГ-н 2023 оны Хөрөнгө оруулалтаар 20 сая төгрөгийн санхүүжилт бүхий эд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шүүгээг шинэчилж сайжруулах | | | | | хөрөнгийн 19 нягтаршуулсан шүүгээ шинээр авлаа. | |
| 3.12 | Архивын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангах | | -Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо<br>-Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 2 | Батлагдсан төлөвлөгөөний дагуу эд хөрөнгийн архивын чиглэлээр 1 арга хэмжээ буюу нягтаршуулсан 19 шинэ шүүгээ авч нөхцлийг сайжрууллаа.Иргэний бүртгэлийн архивын чиглэлээр 5 арга хэмжээ авч 423 хувийн хэргийн 1692 мэдээлэлийг эмхэлж цэгцлэн баримтыг бүрэн оруулллаа. | 100 |
| 3.13 | Хууль тогтоомжийн дагуу холбогдох этгээдэд улсын бүртгэлийн тайлан мэдээ хүргүүлэх | | -Хүргүүлсэн тайлан мэдээний тоо | 12 | 12 | УБЕГ-т сар бүрийн мэдээ-12 удаа аймгийн статистикийн хэлтэст улирлын -2 мэдээг нийт 4 удаа тус тус цаг хугацаанд нь гаргаж хүргүүллээ. | 100 |
| **Зорилт4.Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартын шаардлагыг хэрэгжүүлэх.** | | | | | | | |
| 4.1 | Процесс зураглалыг сайжруулах,өөрчлөлт хийх хэрэгцээг санаачлах | | Төлөвлөгөөний хэрэгжилт хувь | - | 100 | 3 бүртгэлийн чиглэлээр процесс зураглалыг хийж 2 өөрчлөлтийг санаачиллаа.Банк руу явж үйлчилгээний хөлс тушаахгүй пос машин болон киоск дээр тушаадаг болсон.АЗД ын санхүүжилтээр үйлчилгээний нэгдсэн төв дээр цаг харгалзахгүй киоск машинаас үнэ төлбөргүй лавлагаа авах боломжоор хангасан.Мөн хаягийн бүртгэл хийлгэх иргэдийн эд хөрөнгийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гэрчилгээг хэвлэж өгч,багууд дээр нь очиж үйлчлэн 1623 иргэний шилжилт хөдөлгөөнийг хийлээ.Мөн үйлдвэрийн ажилчдад ажлын цагаар үйлчилгээ авч чаддаггүй байдлыг нь харгалзан “Ачит эх” ХХК болон “Эрдмин”ХХК дээр очиж эд хөрөнгийн бүртгэлийн 48 үйлчилгээг үзүүллээ. | |
| 4.2 | Иргэд болон байгууллагуудад зориулсан бүртгэлийн хууль дүрэм журмын сургалт зохион байгуулах | | Явуулсан сургалтын тоо | -1 | 4 | Худалдаа үйлчилгээний томоохон төв болох “Баян худалдааны төв” ийн 135 түрээслэгч,Мобиком корпорацийн 150 ажилтанд 3 бүртгэлийн чиглэлээр газар дээр нь очиж сургалт явууллаа./3 сарын 27,28 ны өдрүүд/Жаргалант сумын иргэдэд чиглэлийн ахлах бүртгэгч нар бүртгэлийн хууль, журмаар 1 удаа сургалт явууллаа./2023.11.21 ны өдөр/Шинээр байгуулагдсан 4 багийн иргэдэд Иргэний ахлах бүртгэгч шилжилт хөдөлгөөний журмын сургалтыг 5 удаа явууллаа. | 100 |
| 4.3 | Мэдээлэлийг дотоодод болон гадагшаа түгээх ажлыг шуурхай зохион байгуулах ил тод байдлыг хангах хэвлэл | | Түгээсэн тараасан мэдээлэлийн тоо | - | .6 | Нийтэд хамааралтай -3 мэдээлэл буюу цахим гадаад паспорт, чиптэй иргэний үнэмлэх,тоон гарын үсэг авах тухай ,болон УБЕГ аас жилийн хугацаанд ирүүлсэн 54 чиглэл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээлэлтэй хамтран ажиллах | | | | | зөвлөмжийг тухай бүр нь бүртгэгч нарт танилцуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж биелэлтийг хугацаанд нь хүргүүллээ.Орон нутгийн- 3 ТВ тэй гэрээ байгуулан сар бүрийн тодруулга булангаар иргэдэд 8 удаа бүртгэлийн чиглэлээр мэдээлэл өглөө.3 бүртгэлийн мэдээлэлийг самбарт ил тод байршуулсан.Орон нутгийн мэдээлэлийн “Эрдэнэт info”,болон Гэрэгтв.mn сайтуудаар иргэн,эд хөрөнгө,хуулийн этгээдийн хууль, журмыг 2 удаа сурталчилж 586 иргэн шэйр хийж үзсэн байна. | |
| 4.4 | Байгууллагын ёс зүйн дүрэм,хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөж ажилласан байх | | Журмын хэрэгжилтийн хувь | - | 100 | Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийг хэлтсийн шуурхай зөвлөлгөөн дээр 29 албан хаагчид танилцууллаа.Мөн Ёс зүйн тухай хуулийн сургалт явуулж бүртгэлийн баярын өдрөөр албан хаагчдын дунд “Ёс зүйтэй төрийн албан хаагч” АСТ зохион байгуулж түрүүлсэн багт шагнал өглөө.Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажлын цаг ашиглалтыг сайжруулж ,урьдчилан сэргийлэх үзлэгт 29 албан хаагчийг 100 хувь хамруулаа.Өөрсдийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | санаачлагаар албан хаагчдын хувцасыг жигдэлж тус бүр нь 147 000 төгрөгөөр ажлын хувцас хийлгэлээ.Иргэдийн гомдол саналгүй дотоод журам, ёс зүйгээ баримтлан ажиллаа. | |
| 4.5 | Хэлтсийн гүйцэтгэлээ үнэлэх,ажилтнуудын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг сайжруулах | | Байгууллагын зорилго,зорилт хүрсэн үр дүн | - | 100 | Процесс зураглалын дагуу үнэлгээний баг албан хаагчдын хагас жилийн гүйцэтгэлийг үнэлж дүгнэн урамшуулал олгож, 1,3 р улирлын ярилцлага хийж засч сайжруулах шаардлагатай 2 арга хэмжээг авч үйлчлүүлэгчийн болон албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаа тус тус хийлээ. | 100 |
| 4.6 | Хэлтсийн дотоод аудиторын эрх авсан ажилтан дотоод аудит хийж үл тохирлуудыг гаргаж илрүүлсэн байх | | Илрүүлсэн үл тохирлын тоо | - | 2 | Тус хэлтэс нь Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байдалд 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн батлагдсан хуваарийн дагуу байгууллагын дотоод аудитын баг дотоод аудитор аудит хийж гүйцэтгэсэн. Аудит хийхдээ 165 шалгуураар бүх бүлэг шаардлагуудыг хангасан эсэхээ шалгах зарчмаар хийсэн бөгөөд аудитын явцад 1 жижиг үл тохирол, 2 зөвлөмж буюу тохиолдол илрүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Үүнд: байгууллагад тоног төхөөрөмжийн нөөц байхгүй 2.Үйлчилгээ авахаар ирсэн иргэдийн хэд нь баримт бичиг , бүрдүүлбэр дутуу буцсан иргэдийн тоог гаргаагүй байх тул энэ талаар судалгаа нотолгоотой болох зөвлөгөө өгч ажиллалаа.Гаргасан үл тохирлыг залруулж 27600 000 төгрөгийн принтер ,скайнерыг ЗД аас шийдүүлж , иж бүрэн 2 шинэ суурин компьютерыг тус тус авч бүртгэгчийн ажиллах нөхцлийг нь бүрдүүлж өглөө.Угтах үйлчилгээний ажилтан ажиллуулж бүртгэлийн үйлчилгээ авч чадахгүй буцаж буй 58 иргэдийн судалгаа авлаа.Эдгээр иргэд нь бүрдүүлбэр дутуу,бүртгүүлэх эрхгүй иргэд ирж буцсан байна. | |
| **Зорилт. 5 Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.** | | | | | | | |
| 5.1 | УБЕГ ын даргын баталсан “Нийгмийн баталгаа хангах” хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдын нийгмийн асуудлыг шат дараатай тавьж шийдвэрлүүлэх | | Хөтөлбөр хэрэгжилтийн хувь | - | 50 | Албан хаагчдын дунд “Барилгачдын талбайгаас Баян-Өндөр “хайрхан хүртэлх явган аялалыг 05 сарын 27 нд зохион байгуулсаны зэрэгцээ урьдчилан сэргийлэх үзлэгт албан хаагчдыг 100 хувь хамрууллаа.Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | судалгааг шинэчлэн гаргалаа.Аймгийн төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөрт 2 албан хаагчид тусламж олгуулахаар тодорхойлолт баримтыг хүргүүллээ. | |
| 5.2 | Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах,төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах | | Төлөвлөгөөний биелэлт % | 100 | 100 | УБЕГ-ын даргатай 2023 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт,37 арга хэмжээ төлөвлөснөөс 36 арга хэмжээний биелэлт цаг хугацаандаа буюу төлөвлөсөн ажлын биелэлт 99 хувьтай байна.1 арга хэмжээ ЭХЭУБГ аас шалтгаалан хэрэгжиж эхлээгүй болно. | 99 |
| 5.3 | Байгууллагын 2023 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах | - | -Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь; | 80 | 100 | 3 багц сургалт дотооддоо төлөвлөсөн бөгөөд 2023 оны жилд 14 сургалтыг явууллаа./Харилцаа хандлагын сургалт багш Алтанцоож гаднаас/ | 100 |
| 5.4 | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарыг хариуцлагын даатгалд бүрэн хамруулах | | Даатгалд хамарсан бүртгэгчийн тоо | - | 100 | УБЕГ аас эд хөрөнгийн бүртгэгч нарыг хариуцлагын даатгалд бүрэн хамруулсан./6 бүртгэгч/ | 100 |
| 5.5 | Иргэн хуулийн этгээдээс иргүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх,хяналт тавьж ажиллах | | -шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо,% | 100 | 100 | 2023 оны жилийн байдлаар иргэдээс хүүхдийн мөнгөтэй холбоотой 6 гомдол, бусад асуудлаар 2 гомдол, 5 санал ирүүлсэнийг ажлын 2 өдөрт багтаан 100 хувь шийдвэрлэж тухайн ээнтэй нь холбогдож | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хариу өглөө.Иргэд e-officce программаар гомдол мэдээлэлээ хянах бүрэн боломжтой боллоо. | |
| **Зорилт 6. “Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх” зорилтын хүрээнд** | | | | | |
| **Д/д** | **Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ** | **Хүрэх түвшин** | **Хэрэгжүүлэх ажил** | **Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/** | **Гүйцэтгэлийн хувь** |
| **“Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль, тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших , тасралтгүй хөгжүүлэх”зорилтын хүрээнд** | | | | | |
| 6.1 | Монгол бичгийн мэдлэг чадвараа дээшлүүлэхээр бие даан суралцах, сургалтад хамрагдах,англи хэлний түвшинг сайжруулах | Монгол бичиг уншдаг болох | Сургалтанд хамрагдсан байна. | Монгол хэл бичгийн болон англи хэлний дунд шатны 25 цагийн онлайн сургалтанд суулаа./төлбөр 147000 төгрөг/ | 100 |
| 6.2 | УБЕГ аас болон аймаг орон нутгаас зохион байгуулсан онлайн болон танхимын сургалтад хамрагдах хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | Ур чадвар дээшилсэн байх | Эрх зүйн мэдлэг дээшилсэн байна. | УБЕГ аас болон орон нутгийн сургалтуудад тухай бүр нь хамрагдлаа.Мөн Койка ОУБ ын шугамаар “Монгол улсын бүртгэлийн тогтолцооны чадавхийг бэхжүүлэх “14 хоногийн сургалтанд хамрагдаж ур чадвараа дээшлүүлсэн.ҮТИС ХЗС- д эчнээгээр суралцан эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж байна. | 100 |

--oOo—